



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, практик шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын баримт бичгийн 1.2.1-д “Монгол Улсын иргэний нисэхийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох” гэж, 1.2.2-т “аялал жуулчлалыг дэмжсэн, иргэдийн нийгмийн хэрэгцээг хангасан, эрэлтэд нийцэхүйц, хүртээмжтэй агаарын тээврийг хөгжүүлэхэд чиглэсэн эдийн засгийн зохицуулалтыг бий болгох” гэж, 1.2.3-т “Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын зөвлөмжийн дагуу иргэний нисэхийн салбарт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шаардлагыг хангахуйц бүтцийн шинэчлэл хийх” гэж, 2.1.2-т “Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын Хавсралтуудын стандарт, зөвлөмжийн шаардлагад нийцүүлэн Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Иргэний нисэхийн багц дүрмийг шинэчлэн боловсруулж батлуулна. Иргэний нисэхийн осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ийн 2.1.5-д “Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлнэ” гэж, “Хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлнэ.” гэж тээврийн салбарын зорилтуудыг тус тус тодорхойлсон.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 71-д Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар тусгасан.

Иргэний нисэхийн тухай хууль 1999 онд батлагдаж, 2001, 2003, 2008, 2011, 2015 болон 2017 онд тус тус нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Хууль тогтоомжийн тухай хууль”, “Захиргааны ерөнхий хууль”, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль” тус тус шинэчлэн батлагдсантай холбогдуулан иргэний нисэхийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага үүссэн.

1.2.Практик шаардлага

Иргэний нисэхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу хийсэн үнэлгээг үндэслэн Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1.Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах үүргийн хэрэгжилтийг хангуулах, нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох болон төрөөс агаарын тээврийн салбарын аюулгүй ажиллагаа, үр ашигтай хөгжлийг дэмжихэд чиглэсэн зохицуулалтыг нэмж тусгах;

2.Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан Иргэний нисэхийн аюулгүй байдлын загвар хуульд нийцүүлэх, холбогдох зохицуулалтыг нэмж тусгах;

3.Иргэний нисэхийн салбарын нэр томьёо, тодорхойлолт хоёрдмол утгатай, өөр өөрөөр тайлбарлан ашиглаж байгаа нь нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байгаа тул Иргэний нисэхийн тухай хуулийн нэр томьёоны тодорхойлолтын хамрах хүрээг ойлгомжтой, ялгамжтай байдлаар томьёолох, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн, иргэний нисэхийн дурмуудэд хэрэглэсэн нэгдмэл утга агуулгаар тодорхойлох;

4.Иргэний нисэхийн тухай хуульд тусгасан нислэгийн үйл ажиллагааны ерөнхий заалтыг нарийвчлан, ерөнхий зориулалтын нисэхийн болон арилжааны нислэгийн үйл ажиллагааны зааг ялгааг тодорхойлох;

5.Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт шаардлага боловсронгуй болж, өөрчлөгдсөнтэй холбогдуулж иргэний нисэхийн дүрмийг батлах “тусгайлан эрх олгосон заалт”-ыг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу тодорхой тусгах;

6.Агаарын хөлгийн бүртгэл болон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшихтэй холбоотой харилцааг хуулиар зохицуулагдаагүй тул олон улсын иргэний нисэхийн байгууллагын загвар хуульд заасны дагуу агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших, агаарын хөлгийг бүртгүүлэхэд Монгол Улсын иргэн, хууль ёсоор оршин суугч иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлагыг нарийвчлан тусгах;

7.Олон улсын иргэний нисэхийн байгууллагын зөвлөмжийн иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын болон үйлчилгээний чиг үүргийг тусгаарлах зорилгоор Иргэний нисэхийн ерөнхий газрыг тохируулагч агентлаг болгох, агаарын навигацийн үйлчилгээ, аэродромын үйлчилгээ болон аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг бие даасан аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлэх зохицуулалт бүрдүүлэх;

8.Түүнчлэн Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралтын дагуу шинжлэн шалгах ажиллагаа гүйцэтгэгч байгууллагыг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хараат бус байхаар зохион байгуулах;

9.Олон улсын иргэний нисэхийн байгууллагын зөвлөмжид иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлэх байгууллагын даргын эрхийг тодорхой хуульчлахыг шаарддаг тул нислэгийн аюулгүй байдлыг салбарын сайд болон иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга биечлэн хариуцдаг байхаар тусгах;

10. Нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтыг үр дүнтэй гүйцэтгэх зорилгоор иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санхүүжилтийн зарчмыг тодорхой тусгах;

11. Агаарын тээврийн болон аэродромын үйлчилгээнд 2003 оноос хойш хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд оролцож эхэлсэнтэй холбогдуулан агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, олон улсын нислэг гүйцэтгэх үндэсний болон гадаадын агаарын тээвэрлэгчид зөвшөөрөл олгох, даатгалын зохицуулалт, үйлчилгээний үнэ тариф, хураамжийн тогтолцоотой холбоотой зохицуулалтуудыг тодорхой болгох;

12. Иргэний нисэхийн салбарын хөгжлийг төрөөс дэмжих, орон нутгийн алслагдсан бус нутагт нийгмийн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг татаасын бодлогоор дэмжих, агаарын тээврийг өргөжүүлэн тогтворжуулахад чиглэсэн оновчтой, үр дүнтэй зохицуулалтыг бий болгох;

13. Агаарын навигацийн хураамжийн тодорхой хувийг нислэгийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтыг санхүүжүүлэх, агаарын навигаци, аэродром, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх болон мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд зориулдаг байх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;

14. Иргэний нисэхийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын хэмжээ бага, тодорхой бус байгаа тул хууль тогтоомж зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах.

Хоёр. Хуулийн төслийн өрөнхий зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 10 бүлэгтэй бөгөөд дараах агуулгатай байхаар боловсруулна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилго, иргэний нисэхийн тухай хууль тогтоомж, иргэний нисэхийн үйл ажиллагааны үндсэн зарчим, хуулийн үйлчлэх хүрээ болон нэр томьёоны тодорхойлолт;

Хоёрдугаар бүлэгт иргэний нисэхийн төрийн зохицуулалт буюу Улсын Их Хурал, Засгийн газар, иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний удирдлагын бүрэн эрх, эрх шилжүүлэх зохицуулалт, нислэгийн аюулгүй байдлын хяналтын байцаагч, түүний бүрэн эрх,

Гуравдугаар бүлэг иргэний нисэхийн дүрэм, иргэний нисэхийн дүрмийн зохицуулалтын хүрээг, дүрмийн шаардлагаас чөлөөлөх, иргэний нисэхэд гадаад хэл хэрэглэх зохицуулалт;

Дөрөвдүгээр бүлэгт агаарын хөлөг, түүнд хамаарах үйл ажиллагаа буюу агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадвар, техник үйлчилгээ, мэргэжлийн ажилтан, сургалт, даргын бүрэн эрх, нислэгийн үйл ажиллагаа, нислэгийн аюулгүй байдлын хариуцлагын зохицуулалт;

Тавдугаар бүлэгт эдийн засгийн зохицуулалт, дүрмийн зохицуулалт, олон улсын болон гадаадын агаарын тээвэрлэгчийн зөвшөөрөл, тээвэрлэгчийн хариуцлага, өмчлөлд тавих хязгаарлалт, агаарын тээвэр дэх өрсөлдөөн, тээвэрлэлтийн гэрээний талаарх зохицуулалт;

Зургаадугаар бүлэгт агаарын навигацийн үйлчилгээ, агаарын зайн зохицуулалт, агаарын хөлөгт тусламж үзүүлэх, нислэгийн зөрчил, навигацийн үйлчилгээний хураамж, түүний зохицуулалт;

Долоодугаар бүлэгт нисэх буудал, аэродромын үйлчилгээ, өмчлөл, ашиглалт, үйлчилгээний хураамжийг тогтоох зохицуулалт;

Наймдугаар бүлэгт нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ, аюулгүйн үзлэг, аэродром, аэронавигацийн байгууламжийн хамгаалалт, агаарын хөлгийн бүхээгийн халдашгүй байдал, хэв журам зөрчсөн зорчигч, агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр зэрэг зохицуулалт;

Есдүгээр бүлэгт агаарын хөлгийн осол, инцидентийг шинжлэн шалгах байгууллага болон түүний даргын бүрэн эрх, шинжлэн шалгагчийн болон шинжлэн шалгах багийн ахлагчийн бүрэн эрх, шинжлэн шалгах ажиллагаанд эрх бүхий байгууллагын хамтын ажиллагаа, оролцоо, шинжлэн шалгах ажиллагааны тайлан, аюулгүй байдлын зөвлөмж гаргах зохицуулалт;

Аравдугаар бүлэгт иргэний нисэхийн үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг, хариуцлага, бусад зохицуулалтыг тусгана.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар дараах үр дүнд хүрнэ гэж тооцож байна. Үүнд:

1.Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас 2010, 2017 онд Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд хийсэн Аудит шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлж, эрх зүйн зохицуулалтыг сайжруулна. Монгол Улсын иргэний нисэхийн эрх зүйн зохицуулалт олон улсын хэм хэмжээнд нийцэж, салбарын урт, дунд хугацааны хөгжлийн стратегитай уялдсан эрх зүйн орчин, түүнийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж, нислэгийн аюулгүй байдал сайжирна.

2.Шинжлэн шалгах ажиллагааны бие даасан, хараат бус байдал хангагдсанаар, осол, зөрчил гарах нөхцөлийг бууруулна.

3.Нислэгийн үйл ажиллагаа, түүнд дэмжлэг үзүүлэх агаарын навигаци, аэродром, аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний чиг үүрэг тодорхой болж, харилцан уялдаатай өргөжин хөгжиж, улс орны эдийн засгийн өсөлтөд дэмжлэг болохуйц иргэний нисэхийн дэд бүтэц, агаарын тээврийн тогтолцоо бүрдэх, бие даасан үйл ажиллагаа явуулах, орон тооны давхардлыг арилгах болон хөрөнгө оруулалтын үр ашиг нэмэгдэх нөхцөл бүрдэнэ.

4.Хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих, зах зээлийн шударга өрсөлдөөнийг бий болгох, агаарын тээврийн тогтвортой байдалыг хангах, нийтэд хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх нөхцөлүүд бүрдэнэ.

5. Иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгож, иргэний нисэхийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нислэгийн аюулгүй байдалтай холбоотой хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгосноор төр, иргэн, хуулийн этгээдийн хариуцлага дээшилнэ.

6. Ерөнхий зориулалтын, арилжааны болон арилжааны бус нислэгийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд тодорхой, нийтэд ойлгомжтой байдлаар зохицуулснаар агаарын тээврийн тэгш оролцоог хангах, хөрөнгө оруулалт, тээврийн үр ашгийг нэмэгдүүлэх боломж бурдэнэ.

7. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг чиг үүргийнх нь дагуу Засгийн газрын тохируулагч агентлаг болгон өөрчлөн зохион байгуулах тул шинээр агентлаг байгуулахгүй болно. Бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор улсын төсөвт дарамт учрахгүй, мөн агентлагийн орон тоо дунд хугацаанд нэмэгдэхээргүй байхаар тооцсон.

8. Засгийн газрын агентлагийн үзүүлж байсан агаарын навигацийн болон нисэх буудал, нисэхийн аюулгүй хамгаалалтын үйлчилгээг үзүүлэх төрийн өмчит аж ахуйн нэгжийг байгуулах Эрх зүйн зохицуулалт бүрдсэнээр орон нутгийн өмчийн болон хувийн өмчийн нисэх буудал, аэродром байгуулах, орон нутгийн агаарын тээврийн дэд бүтцийг сайжруулах зэрэг ач холбогдолтой байхаар байна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулттай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Энэ хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуульд нийцүүлэн боловсруулна.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Улсын нисэхийн тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Агаарын зайлж нисэхэд ашиглах тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай зэрэг хуулиудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах, Иргэний нисэхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг боловсруулна.

—oOo—